



I-X/2022

Тархаасан: 2022 оны 11 дүгээр сарын 21



Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 838 болж, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өслөө


Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2022 оны 10 дугаар сард 837 болж, өмнөх оны мөн үеэс 378 (1.8 дахин) хүнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 465 (55.4%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангилалаар, жил бүрийн 10 дугаар сарын эцэст

Үзүүлэлт	2021-X		2022-X	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	тоо			
Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд	415	226	890	491
Тухайн сард нэмэгдсэн ажилгүйчүүд	224	121	273	158
Тухайн сард бүртгэлээс хасагдсан	180	-	325	-
Үүнээс: Ажилд зуучлагдсан	113	-	9	-
Тухайн сарын эцэст байгаа ажил хайгч иргэн	459	259	838	465
Үүнээс: Насны ангиллаар				
15-24	42	20	48	23
25-34	173	98	339	182
35-44	138	83	289	167
45-54	71	41	133	88
55-59	28	12	26	4
60+	7	5	3	1

¹-дахин

ЗУРАГ 1. ДҮҮРГИЙН АЖИЛГҮЙЧҮҮД, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, 2022 оны 10 дугаар сард




Бүртгэлтэй нийт ажил хайгч иргэний 48 нь (5.7%) 15-24 насны, 339 нь (40.4%) 25-34 насны, 289 нь (34.5%) 35-44 насны, 133 нь (15.9%) 45-54 насны, 26 нь (3.1%) 55-59 насны, 3 нь (0.4%) 60-аас дээш настай байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 8 (0.9%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 4 (0.5%) нь эмэгтэйчүүд байна.

Дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2022 оны 10 сард 273 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 9 иргэн ажилд зуучлагдан орж, 316 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар


бүртгэлээс хасагдсан байна. 2022 оны 10 дугаар сард 273 ажилгүй иргэн шинээр бүртгүүлснээс 18 нь (6.6%) сургууль төгсөөд ажилгүй байгаа, 8 нь (2.9%) шилжин суурьшсан, 243 нь (89%) ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан, үлдсэн 4 нь (1.5%) бусад шалтгаанаар ажил хайж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН, АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн 10 дугаар сард



Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 дахин өссөн бол, ажилд зуучлагдан орсон иргэд 8 хувиар буурсан сөрөг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 10 дугаар сард



2022 оны 10 дугаар сарын эцэст бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 28.9 хувийг бүрэн дунд, 66.6 хувийг дипломын болон бакалаврын дээд, 2.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.0 хувийг техникийн болон мэргэжлийн анхан шат, 0.6 хувийг магистр, доктор, 0.2 хувийг суурь, 0.1 хувийг бага боловсролтой 0.1 хувийг боловсролгүй иргэд тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ажилгүй хүн: Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажил хайж байгаа: Сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ

Дараагийн танилцуулга тархаах хугацаа:

2022 оны 12 дугаар сарын 20

Мэдээлэл авах холбоос:

<http://www.ubstat.mn/>

Статистикийн хэлтсийн дарга
Г.Чинжаргал
Утас: (976)-70122666

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
А.Динар
Утас: (976-11)-301637